



**“ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 3 сарын 11-ний өдөр

Дугаар 24/06.

Улаанбаатар хот

Компанийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.3 дахь заалт болон “Хот Девелопмент” ХК-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.33 дэх хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хот Девелопмент” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэхүү төлөвлөгөө, төсвийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг ТУЗ-ийн дарга Э.Баярбат-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  Э.БАЯРБАТ



“Хот Девелопмент” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2024 оны 3 сарын 11-ний өдрийн 2024/06 тоот тогтоолын  
Хавсралт № - 2



Компанийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө

“Хот Девелопмент” ХК нь 2024 онд санхүүгийн үзүүлэлтээ сайжруулах, дотоод зохион байгуулалтдаа өөрчлөлт хийх, чадварлаг хүний нөөцөөр багаа бүрдүүлэхэд анхааран ажиллахаас гадна стратеги, зорилго зорилтоо тодорхойлон ажиллахаар төлөвлөөд байна.

“Хот Девелопмент” ХК-ийн 2024 онд хэрэгжүүлэх зорилтууд:

1. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тусгай зөвшөөрлийг авах;
2. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тусгай зөвшөөрлийн авахар шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах;
3. Хүний нөөцийн бүтэц бүрэлдэхүүнийг тодорхойлох, чадварлаг боловсон хүчнээр багаа бүрдүүлэх;
4. Шинэ төсөл, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх;
5. Хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн мэдээ мэдээллийг нээлттэй, ил тод, түргэн шуурхай хүргэх дотоод тогтолцоог бий болгох.

Компанийн 2024 оны үйл ажиллагааны төсөв

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын төсөв
2. ТУЗ-ийн гишүүдийн цалин, хөлс
3. ТУЗ-ийн хурлын зардал
4. ISO/IEC 27001:2013 магадлан аудитын хөлс
5. Ажилтнуудын цалин, хөлс г.м



**“ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 3 сарын 11-ний өдөр

Дугаар 24/05

Улаанбаатар хот

ТУЗ-ийн дэргэдэх хороодын 2023 оны үйл ажиллагааны тайлангийн тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.3 дахь заалт болон “Хот Девелопмент” ХК-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.33 дэх хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хот Девелопмент” ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны 2023 оны үйл ажиллагааны тайлантай танилцсантай тооцсугай.
2. “Хот Девелопмент” ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны 2023 оны үйл ажиллагааны тайлантай танилцсантай тооцсугай.
3. “Хот Девелопмент” ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны 2023 оны үйл ажиллагааны тайлантай танилцсантай тооцсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  Э.БАЯРБАТ





**“ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 3 сарын 11-ний өдөр

Дугаар 24/04

Улаанбаатар хот

2023 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайлангийн тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт болон “Хот Девелопмент” ХК-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.20.11 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хот Девелопмент” ХК-ийн 2023 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнд тооцсугай.
2. “Хот Девелопмент” ХК-ийн 2023 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс хавсралтанд дурдсан дүгнэлийг гаргасугай.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  Э.БАЯРБАТ

“Хот Девелопмент” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2024 оны 3 сарын 11-ний өдрийн .../... тоот тогтоолын  
Хавсралт № - .../...



### ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК – ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

2024 оны 3 сарын 11-ний өдрийн байдлаар “Хот Девелопмент” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц дараах байдалтай байна.

<u>Хувьцаа эзэмшигч</u>	<u>Хувь</u>	<u>Тоо ширхэг</u>
Финова Корпорейшн ХХК	70.76%	20,500,000
Ч.Солонго	9.71%	2,813,625
Б.Чулуун-Эрдэнэ	9.65%	2,794,271
Э.Баярбат	9.71%	2,813,625
5 хүртэлх хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид	0.17%	48,533
<b>Нийт</b>	<b>100%</b>	<b>28,970,054</b>

#### 1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн хэрэгжилтийн тухай

“Хот Девелопмент” ХК нь 2023 онд бизнесийн үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна. 2023 оны 2 сарын 28-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа хийсэн. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах 11 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай
2. Санхүүгийн тайланд хийсэн хараат бус аудитын дүгнэлттэй танилцсан тухай
3. 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг батлах тухай
4. ТУЗ-ийн гишүүдийг томилох тухай
5. ТУЗ-ийн хараат бус гишүүдийн цалин, үйл ажиллагааны төсөв батлах тухай
6. ТУЗ-өөс гаргасан ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийн батлах тухай
7. Хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргах, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өсгөхийг батлах тухай
8. Үйл ажиллагааны чиглэлд нэмэлт, өөрчлөлт оруулахыг батлах тухай
9. Хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэх тухай
10. Шаардах эрхийг хэрэгжүүлэх тухай
11. Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай



Энэхүү хурлаар шийдвэрлэсэн асуудлын нэг болох үйл ажиллагааны чиглэлд нэмэлт өөрчлөлт оруулж, хаягийн өөрчлөлтийг хийсэн ба компани одоогийн байдлаах дараах чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхээр Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлсэн.

Үйл ажиллагааны чиглэл:

- Бизнесийн зөвлөгөө өгөх
- Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа
- Мэдээллийн технологийн үйл ажиллагаа
- Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх

Үйл ажиллагаа эрхлэх хаяг:

- Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Их хуралдай оффис, 7 давхар, 704 тоот

Энэхүү хурлаар шийдвэрлэсэн асуудлын хүрээнд хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргасан бөгөөд холбогдох зөвшөөрлийг Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 4 сарын 18-ны өдрийн А/57 дугаартай шийдвэр болон Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 6 сарын 13-ны өдрийн 210 дугаартай тогтоолоор тус тус авсан.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэх, өөрийн эзэмшиж буй хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэж өдөр тутмын сонин (Өдрийн сонин) болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар мэдээлж зараа түгээсэн боловч хувьцаа эзэмшигчдээс энэхүү эрхээ хэрэгжүүлэхээр хүсэлт ирүүлээгүй болно.

Иймд, хууль тогтоомжид заасан хугацаа өнгөрсний дараа хөрөнгө оруулагч “Финова Корпорейшн” ХХК буюу хуучин нэрээр “Занн Корпорейшн Монголиа” ХХК-тай 2023 оны 6 сарын 14-ний өдөр 23/ХХАГ-02 тоот хувьцаа худалдах, худалдан авах гэрээ болон 23/ЭШГ-03 дугаартай Эрх шилжүүлэх гэрээ тус тус байгуулж нотариатаар гэрчлүүлсэн. Гэрээний дагуу нэмж гаргасан 20,500,000 ширхэг хувьцааг “Финова Корпорейшн” ХХК буюу хуучин нэрээр “Занн Корпорейшн Монголиа” ХХК руу шилжүүлж Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК болон Монголын хөрөнгийн биржид тус тус бүртгүүлсэн.

Компанийн одоогийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон хувьцааны талаарх мэдээлэл:

- Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ: 100 төгрөг
- Гаргасан хувьцааны тоо: 28,970,054 ширхэг
- Хувь нийлүүлсэн хөрөнгө: 2.897,005,400 төгрөг

“Финова Корпорейшн” ХХК-тай байгуулсан дээрх гэрээтэй холбоотой “Тухай бүр мэдээлэх тайлан”-г хороо, биржид хүргүүлж мэдээлсэн.

Ийнхүү, “Хот Девелопмент” ХК-ийн дүрмийн өөрчлөлтийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт 2023 оны 6 сарын 26-ны өдөр бүртгүүлсэн.

## **2. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний тухай**

“Хот Девелопмент” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь ердийн 6, хараат бус 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр компанийн дүрмээр олгосон бүрэн эрхийн хүрээнд тогтвортой, тасралтгүй үйл ажиллагааг явуулж байна.

Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 2 сарын 28-ны өдрийн ээлжит хурлаас компанийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр Э.Баярбат, Ч.Солонго, Б.Чулуунсүх, Л.Алтангэрэл, С.Отгонсайхан М.Дөлгөөн хараат бус гишүүнээр Э.Эрдэнэбаатар, Б.Лхамдэгд, Э.Ганбаатар нар тус тус томилогдон ажиллаж байсан.

Компанийн хараат бус гишүүн Б.Лхамдэгд нь 2023 оны 8 сарын 3-ны өдөр өөрийн хүсэлтээр ТУЗ-ийн хараат бус гишүүнээс чөлөөлөгдсөх хүсэлт гаргасан тул Б.Лхамдэгдийг ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлж, Компанийн тухай хуулийн 77.5-д заасны дагуу Б.Баярмааг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр нөхөн сонгууль хүртэл түр томилсон.

ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Б.Баярмааг томилохдоо ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооноос хараат бус гишүүнийн шаардлагыг хангаж буй эсэх болон мэргэжил ур чадварын судалгаа хийж дүгнэлт гаргаж байсан.

Ийнхүү ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсныг МХБ болон СЗХ-д мэдэгдэж бүртгүүлсэн болно.

ТУЗ-ийн гишүүд нь Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо гэсэн 3 хороонд хуваагдан ажиллаж байна.

ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Б.Номинг ТУЗ-ийн 2023 оны 7 сарын 26-ны өдрийн 23/19 тоот тогтоолоор томилон ажиллуулж байна.

Компанийн тухай хуулийн 75.8 дугаар зүйлд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нар компанийн засаглалын сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан.

### **3. Компанийн засаглалын кодексын хэрэгжилтийн тухай**

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 3 сарын 1-ний өдрийн 23/12 тоот тогтоолоор компанийн засаглалын кодексын хүрээнд дараах (нийт 17) дүрэм, журам, бодлого, зааврыг баталсан.

- “Хот Девелопмент” ХК-ийн Хөдөлмөрийн дотоод журам
- “Хот Девелопмент” ХК-ийн Ёс зүйн дүрэм
- “Хот Девелопмент” ХК-ийн Цалин урамшууллын бодлого
- “Хот Девелопмент” ХК-ийн Ногдол ашгийн бодлого
- “Хот Девелопмент” ХК-ийн Эрсдэлийн удирдлагын заавар
- “Хот Девелопмент” ХК-ийн Дотоод аудитын заавар
- “Хот Девелопмент” ХК-ийн Дотоод хяналтын заавар
- “Хот Девелопмент” ХК-ийн Комплайнсын хяналтын заавар
- “Хот Девелопмент” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам
- “Хот Девелопмент” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам
- “Хот Девелопмент” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журам
- “Хот Девелопмент” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны үйл ажиллагааны журам

- “Хот Девелопмент” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журам
- “Хот Девелопмент” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны үйл ажиллагааны журам
- “Хот Девелопмент” ХК-ийн Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам
- “Хот Девелопмент” ХК-ийн Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам
- “Хот Девелопмент” ХК-ийн Залгамж халааны бодлого

Ийнхүү холбогдох дүрэм, журам, заавар, бодлогыг баталж компанийн үйл ажиллагаанд мөрдөн ажилласнаар “Хот Девелопмент” ХК-ийн компанийн засаглалын хэрэгжилт сайжирч Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хорооноос ирүүлсэн компанийн засаглалын хэрэгжилтийн үнэлгээний хянан баталгаажилт сайжирсан.

#### **4. ISO 27001:2013 стандартыг хэрэгжүүлсэн тухай**

“Хот Девелопмент” ХК нь ISO/IEC 27001:2013 буюу Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог үйл ажиллагаандаа хэрэгжүүлж Бүгд Найрамдах Энэтхэг улсын олон улсын баталгаажуулалтын SIS Certifications Pvt,Ltd компаниас хянан баталгаажилтын гэрчилгээг 2023 оны 5 сарын 24-ний өдөр авсан.

#### **5. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн зөвшөөрлийн тухай**

Компани нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн зөвшөөрөл авахаар холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн Санхүүгийн зохицуулах хороонд хүсэлт гаргасан бөгөөд хяналт шалгалтын шатанд явж байна.





**“ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 3 сарын 11-ний өдөр

Дугаар 24/03

Улаанбаатар хот

2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт болон “Хот Девелопмент” ХК-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.20.11 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хот Девелопмент” ХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хэлэлцсэнд тооцсугай.
2. “Хот Девелопмент” ХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийсэн “Пантер Мидланд Аудит” ХХК-ийн 2024 оны 2 сарын 26-ны өдрийн 24/02 тоот дүгнэлттэй танилцсан болохыг дурдсугай.
3. “Хот Девелопмент” ХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс хавсралтанд дурдсан дүгнэлтийг гаргасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  Э.БАЯРБАТ



“Хот Девелопмент” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2024 оны 3 сарын 11-ний өдрийн 2024/03 тоот тогтоолын  
Хавсралт № - .....



**ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК – ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ**

**2023 оны санхүүгийн тайлангийн талаар**

“Пантер Мидланд Аудит” ХХК нь 2023 оны жилийн эцсийн тайланд хараат бус аудит хийж дүгнэлт гаргасан ба аудитын дүгнэлтээр “Хот Девелопмент” ХК-ийн санхүүгийн тайлангууд нь СТОУС-ын дагуу материаллаг алдаагүй үнэн зөв илэрхийлэгдсэн байна гэж дүгнэжээ.

Компани санхүүгийн тайлан тэнцэл, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татварын тайлан тооцоог цаг хугацаанд нь гаргаж, дүүргийн санхүүгийн хэлтэс, татварын байгууллагад хуульд заасан хугацаанд хүргүүлсэн.

Санхүүгийн үйл ажиллагаанд одоогоор гарсан томоохон гүйлгээ үл хөдлөх хөрөнгө худалдан авалт хийгдээгүй байна.